



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/621

Булган сум

### Албан томилолтоор ажиллахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9 дэх заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн төлөөлөгчид 2023 оны 09 дүгээр сарын 02-05-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсын Буриад улсад албан томилолтоор ажиллахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 9,547,160 (есөн сая таван зуун дөчин долоон мянга нэг зуун жар) төгрөгийг “Шинэ ирээдүй” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

08 дугаар сарын 31-ны өдрийн 16/621 дугаар захирамжийн хавсралт



ГАДААД АРГА ХЭМЖЭЭНД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Мөнгөн дүн /төгрөг/
2	Шатахуун	224литр*3,550=795,200
3	Томилолт	210*3473*3 хоног=2,187,990 2,187,990*4 хүн =8,751,960
	<b>Нийт дүн</b>	<b>9,547,160</b>